

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 3 сарын 16 өдөр

Дугаар: 25/01/02

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.1 , 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтинер Лэнд Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4-р сарын 30-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4-р сарын 07 өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 2. Компанийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
 4. “Морьт Импекс” ХХК-тай байгуулах гэрээг дүгнэх, шаардлагатай арга хэмжээг авах
 5. Бусад
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2025 оны 3-р сарын 21-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2025 оны 4-р сарын 07-нд уг зарыг давтан, 2025 оны 3-р сарын 26-ны дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 4-р сарын 28-ны өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2025 оны 4-р сарын 01 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Р.Отгонбат, гишүүнээр, Д.Батсайхан, Тооллогын комиссийн даргаар Д.Чулуунбаатар, гишүүнээр Х.Мөнгөнцэцэг нарыг тус тус томилсугай.
10. “Фронтнер Лэнд Групп”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.МАШБАТ